



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 440

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 50,652,795.53 (тавин сая зургаан зуун тавин хоёр мянга долоон зуун ерэн таван төгрөг тавин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Халдварт өвчин судлалын үндэсний төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 59,855,034.27 (тавин есөн сая найман зуун тавин мянга гучин дөрвөн төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Халдварт өвчин судлалын үндэсний төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

3. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Содномжамц, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн зохицуулагч А.Оюунбилэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Д.Нямхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн
~~110~~ дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ландкрузейр-76, 75-21 УБЧ, суудлын, хөдөлгүүр-0618719, арал-ЈТЕЕВ711307006216	2009	50,652,795.53	50,652,795.53	-
	НИЙТ ДҮН	-	50,652,795.53 (тавин сая зургаан зуун тавин хоёр мянга долоон зуун ерэн таван төгрөг тавин гурван мөнгө)	50,652,795.53 (тавин сая зургаан зуун тавин хоёр мянга долоон зуун ерэн таван төгрөг тавин гурван мөнгө)	-

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн
~~770~~ дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ-ЫН ТӨСЛИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ландкрузейр-GRJ200L, 75-24 УБЧ, суудлын, хөдөлгүүр-5753865, арал-JTMCU09J304021530	2009	59,855,034.27	59,855,034.28	-
	НИЙТ ДҮН	-	59,855,034.27 (тавин есөн сая найман зуун тавин таван мянга гучин дөрвөн төгрөг хорин долоон мөнгө)	59,855,034.27 (тавин есөн сая найман зуун тавин таван мянга гучин дөрвөн төгрөг хорин долоон мөнгө)	-